



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 144

Улаанбаатар хот

Хорооны 2013 оны 280 дугаар тогтоолоор
батлагдсан журамд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 160 дугаар тогтоолоор “Хаалттай ХК-ийн хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх эрх шилжүүлэх үйл ажиллагааны журам” батлагдсаныг ТЭМДЭГЛЭН, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 280 дугаар тогтоолоор батлагдсан “Хаалттай хувьцаат компанийн тухай журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсгийн “...эдгээр журмыг хадгаламжийн байгууллага Хороонд батламжлуулсны үндсэнд өөрөө тогтооно” гэснийг “...Хорооноос тогтоосон журмаар зохицуулна.” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “...тогтоомжид нийцүүлэн өөрөө тогтооно.” гэснийг “...тогтоомж, Хорооноос тогтоосон журмаар зохицуулна.” гэж, мөн зүйлийн 4.2 дахь хэсгийн “...Хадгаламжийн байгууллагын үндэслэх бичиг баримт нь худалдагч, худалдан авагч талын хооронд байгуулсан гэрээ, өв залгамжлах эрхийн гэрчилгээ, бэлэглэлийн гэрээ, шүүхийн шийдвэр байх бөгөөд бусад шаардлагатай бичиг баримтыг хадгаламжийн байгууллага холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн өөрөө тогтооно.” гэснийг “...холбогдох хууль тогтоомж, Хорооноос тогтоосон журмаар зохицуулна.” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Журамд өөрчлөлтийг оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000172